



“МОН-ГЕО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2023 оны 3-р сарын 17 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай

“Монгол улсын компанийн тухай хууль”-ийн 59.4 дүгээр зүйл, “Мон-гео” ХК-ийн дүрмийн 6.2 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг үндэслэн

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :

Нэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит Хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10 цагт “Мон-гео” ХК-ийн байранд хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлаар дараахи асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн эцсийн тайлангийн талаар ТУЗ-ийн хурлын шийдвэрийг хэлэлцэж батлах,
2. Санхүүгийн тайланд өгсөн аудиторын дүгнэлтийг хэлэлцэх.
3. Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэлээр улсын болон орон нутгийн чанартай зохион байгуулагдах ажилд идэвхийлэн оролцох, шаардагдах төсвийг тооцож, төлөвлөгөөг гаргаж тухай бүрт нь ТУЗ-ийн хурлаар шийдвэрлүүлэх,
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгох
5. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, ажлын байр нэмэгдүүлэх, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилготойгоор их хэмжээний зээл авах, гэрээ хэлцэл байгуулахыг гүйцэтгэх захиралд зөвшөөрөх,
6. Тус компанийн эзэмшлийн ХУД-ийн 12-р хорооны нутаг дэвсгэрт байрлалтай 8,08 га газар дээр хүнс, хаа -н бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн болон бусад зорилгоор ашиглах төсөл, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, эхлүүлэх ажлыг зохион байгуулахыг компанийн удирдлагад үүрэг болгох,
7. Гүйцэтгэх удирдлагыг өөрчлөх саналыг хэлэлцэх.

ГУРАВ. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үүнд: Комиссын дарга - Х.Анар

Комиссын нарийн бичгийн дарга- Э.Норовринчин

ДӨРӨВ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга
Н.Соёмбыг томилсугай.

ТАВ. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Үүнд :

Комиссын дарга - Г.Даваажаргал

Гишүүн - Б.Түмэнжаргал

Гишүүн – Н.Бат-өлзий

Зургаа . 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын нэрсийн жагсаалт гаргах
бүртгэлийн өдрийг 2023 оны 04 дүгээр сарын 06 –ний өдрөөр тогтоосугай.

Долоо. Компанийн хувьцаа эзэмшигчдэд хурлыг хуралдуулах тухай мэдэгдэх
өдрийг 2023 оны 03-р сарын 22 –ний өдөр , 2023 оны 04 –р сарын 06 –ний өдрөөр тус тус
тогтоосугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах зохион байгуулалтыг
компанийн тухай хуулийн 59.8 , 59.9 дэхь заалтуудыг хэрэгжүүлж ажиллахыг комиссын
дарга –/Х.Анар/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ийн дарга /Н.Соёмбо /

